

“ШИВЭЭ-ОВОО” ХК

2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР БИЧИГ

НЭГ. ТОВЧ АГУУЛГА

2016 оны эхний хагас жилд 3914.5 мян.м³ хөрс хуулж (тээвэртэй 2782.9 мян.м³, тээвэргүй 1131.6 мян.м³), 846.2 мян.тн нүүрс олборлон 839.8 мян.тн нүүрс борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөө 108.3 хувь, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөө 95.9-97.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Тээвэртэй хөрс хуулалт 125.7 хувь, тээвэргүй хөрс хуулалт 80.7 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт, борлуулалтын хэмжээ 96.5-101.3 хувийн гүйцэтгэлтэй, хөрс хуулалт 122.5 хувийн, нийт уулын цулын хэмжээ 114.2 хувийн гүйцэтгэлтэй тус тус гарсан байна.

2016 оны 2-р улиралд компани 20294.5 сая төгрөгийн орлого олж, 22356.3 сая төгрөгийн зардал гарган 2061.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс 20477.9 сая төгрөгийн орлого олж 20954.2 сая төгрөгийн зардал гарган 476.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаа. Ийнхүү алдагдалтай ажилласан нь үндсэн 2-н шалтгаантай бөгөөд Үүнд:

1. Нүүрс борлуулалтын хэмжээ жилийн төлөвлөгөөнөөс 36.0 мян.тн буюу 4.1 хувиар буурч борлуулалтын орлого төлөвлөснөөс 1.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2. Өнгөрсөн оны мөн үед 835.3 мян.тн нүүрс олборлон, 870.2 мян.тн нүүрс борлуулж 20537.4 сая төгрөгийн зардал гаргахад нэгжийн өртөг 23211.8 төгрөг байсан бол 2016 оны эхний хагас жилд 846.2 мян.тн нүүрс олборлон, 839.8 мян.тн борлуулж 20954.2 сая төгрөгийн зардал гаргаж нэгжийн өртөг 22374.5 төгрөг болж байна.

Өнөөдрийн түвшинд хэдийгээр алдагдал буурсан харагдаж байгаа боловч өнөөдөр хуулж чадаагүй хөрсний хэмжээгээр ирээдүйд хуулах хөрс нэмэгдэж, ирээдүйд гарах зардал өснө.

ХОЁР. НҮҮРС БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААР

2016 оны эхний хагас жилд 839.8 мян.тн нүүрс борлуулж, нүүрс борлуулалтын орлого 18845.5 сая төгрөг болж, борлуулалтын төлөвлөгөө 4.1 хувиар буюу 1122.0 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

ДЦС-IV ХК-д батлагдсан бизнес төлөвлөгөөгөөр 875.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 752.9 мян.тн нүүрс нийлүүлж, харин вагон пүү, туузан пүүний зөрүү 30.8 мян.тн буюу 792.8 сая төгрөг болж байна.

2016 оны 4-р улиралд ДЦС-IV, Амгалангийн ДС-ууд оны эхний дутуу нүүрсээ авч, нүүрс борлуулалтын төлөвлөгөө биелүүлэх прогноз хийж байна.

Нүүрс борлуулалтын зах зээлийн томоохон

хэрэглэгчдийг үзүүлбэл:

/ нүүрс мянган тонноор /

Д д.	Хэрэглэгч	2015 оны 1-6 сар	2016 оны эхний хагас жилийн		Төлөвл өгөө тасарс ан хэмжээ	Өмнөх онтой харьцу улахад	Борлуул алтанд эзлэх хувийн жин
			Төлөвлөг өө	гүйцэтгэ л			
1	ДЦС-IV ТӨХК	804.5	780.0	752.9	-27.1	-51.6	89.7
2	Амгалан ДС	0	0	0			
3	УБ Төмөр зам	15.4	23.0	19.8	-3.2	4.4	2.4
4	Бор өндөр УБҮ	14.5	19.0	22.1	3.1	7.6	2.6
	Налайх ДС	0	3.5	0	-3.5		
5	Дорноговь ЭХНҮ	16.4	19.1	17.6	-1.5	1.2	2.1
6	Говьсүмбэр	5.7	26.5	6.3	-20.2	0.6	0.8
7	Төв Чандмань ЭХНҮ	0	0	0			
8	Бусад	14.3	3.9	21.1	-17.2	6.8	2.5
	Дүн	870.8	875.8	839.8	-36.0	-31.0	100.0

2016 оны эхний хагас жилд нүүрс борлуулалтын аж ахуйн гэрээний биелэлт 95.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

ГУРАВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРТӨГ ЗАРДЛЫН ТАЛААР

2016 оны эхний хагас жилд гүйцэтгэлээр нүүрс борлуулалтын өртөг төлөвлөсөн хэмжээнээс 16.5 хувь буюу 3613.8 сая төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.6 хувиар буюу 104.8 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт гарч байна.

Энэ хугацаанд нэг тонн нүүрсийг 22374.5 төгрөгөөр олборлон 22440.3 төгрөгөөр борлууллаа. Нүүрс борлуулалтын нэгж тутамаас 65.5 төгрөгийн ашиг хүлээсэн. Өнгөрсөн оны мөн үеэс 1 тонн нүүрсний өртөг 882.7 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн уулын цулын нэгжийн өртөг төлөвлөсөн хэмжээнээс 13.2 хувь буюу 478 төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеэс 426 төгрөгөөр тус тус буурсан байна.

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлэв.

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй нийт зардлаас оны эхнээс төлөвлөснөөс 14 нэр төрлийн зардал гүйцэтгэлээр 2721.8 сая төгрөгөөр буурч, 6 төрлийн зардал 968.9 сая төгрөгөөр хэтэрч, дүнгээрээ 1752.9 сая төгрөг хэмнэсэн үзүүлэлттэй гарч байна.

Нийт зардлын бууралтын 709.0 сая төгрөг биет зарцуулалтын тоо хэмжээний хэмнэлт, 2012.8 сая төгрөг үнийн хэмнэлт тус тус эзэлж байна.

а) Хэтэрсэн зардлуудыг авч үзвэл:

1. Тэсрэх материалын зардал төлөвлөсөн хэмжээнээс 20.4 хувь буюу 211.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тээвэртэй хөрс хуулалт 569.6 мянган шоометр нэмэгдсэнтэй холбоотойгоор тэсрэх бодисын биет хэмжээгээр 156.8 тн-оор өссөн. Өмнөх оны мөн үеийнхээс тэсрэх материалын зардал 69.8 сая төгрөгөөр буурсан байна.
2. Сэлбэг хэрэгслийн зардал төлөвлөсөн хэмжээнээс 290.8 сая төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 321.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Сэлбэгийн зардлын судалгааг хавсаргав.
3. ҮХХ татвар, УАТ 24.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ус шүүрүүлэлт төлөвлөгөөнөөс 77.7 мянган шоометрээр өссөнтэй холбоотой байна.
4. Гэрээт ажлын хөлс 442.8 сая төгрөгөөр өссөн нь 2015 онд хийгдсэн 507,0 сая төгрөгийн хөрс хуулалтын ажлын гэрээ дүгнэсэн акт он дамжин хийгдэж 2016 онд зардалд бүртгэгдсэнтэй холбоотой.

б) Хэмнэгдсэн зардлуудыг авч үзвэл:

1. Дизель түлшний зардал төлөвлөгөөнөөс 28.9 хувь буюу 1189.3 сая төгрөгөөр буурсан байна. Дизель түлшний биет хэмжээний зарцуулалтаас / (2491.7- 2178.0) 313.7 х 1341.6 = / 420.9 сая төгрөгөөр буурсан байна. Дизель түлшний үнийн хэмнэлт / (1650-1341.6) х 2178.0 = 671.7 сая төгрөг болж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 175.5 сая төгрөгөөр зардал буурсан байна. Мөн дизель түлшний нэгжийн үнэ 18-20 хувиар буурсан байна.

2. Бензиний зардал төлөвлөгөөнөөс 29.3 хувь буюу 18.0 сая төгрөгөөр буурсан байна. 2016 оны эхний хагас жилд бензиний зарцуулалтаас / (27.1-12.2) 14.9 х 2286 = / 34.1 сая төгрөгөөр, бензиний нэгжийн үнийн бууралтаас 16.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс 12.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

3. Тос, тослох материалын зардал төлөвлөгөөнөөс 7.4 хувь буюу 26.6 сая төгрөгөөр буурсан байна. Биет зарцуулалтаар / (71.1-69.6) 1.5 х 4768 / 7.2 сая төгрөгөөр, үнийн өөрчлөлтөөс / (5041-4768) 273 х 69.6 / 19.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.6 хувь буюу 8.8 сая төгрөгөөр буурсан байна.

4. Цахилгаан эрчим хүчний зардал төлөвлөгөөнөөс 20.1 хувь буюу 311.7 сая төгрөгөөр буурсан байна. Биет хэмжээний зарцуулалтаас 1693.9

мян.квт хэмнэж байгаа нь төлөвлөсөн уулын ажлын бууралттай холбоотой байна.

5. Дулааны зардал төлөвлөгөөнөөс 3.8 сая төгрөгөөр буурсан байна.
6. Дугуйн зардал төлөвлөгөөнөөс 9.4 хувь буюу 35.4 сая төгрөгөөр буурсан нь автосамосвалууд дугуйн нормоо давуулж ашиглаж байгаатай холбоотой. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 41.9 сая төгрөгөөр буурсан.
7. Хөдөлмөр хамгааллын зардал төлөвлөсөн хэмжээнээс 198.6 сая төгрөгөөр буурсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24.5 сая төгрөгөөр буурсан байна.
8. Цалин хөлсний зардал төлөвлөсөн хэмжээнээс 4.2 хувь буюу 152.9 сая төгрөгөөр буурсан байна. Ажилчдын сарын цалингийн дундаж 1214.9 мянган төгрөгт хүрээд байна. Цалингийн сан 188.2 тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн нь төлөвлөгөө биелээгүй зарим саруудад сарын үр дүнгийн олгогдоогүйтэй холбоотой. Нийт цалингийн сан өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.2 хувь буюу 453.2 сая төгрөгөөр өсч, ажилчдын дундаж цалин 156.7 мян төгрөгөөр өссөн байна.
9. Ашигт малтмал ашигласны төлбөр төлөвлөсөн хэмжээнээс 28.1 сая төгрөгөөр борлуулалтын орлогын бууралтаас хамаарч, өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 19.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.
10. Вагон ашиглалтын зардал төлөвлөгөөнөөс 33.7 хувь буюу 38.6 сая төгрөгөөр буурсан нь нүүрс борлуулалтын хэмжээ төлөвлөгөөнөөс 36.0 мянган тонноор тасарсантай холбоотой.
11. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 301.1 сая төгрөгөөр буурсан нь ХОТЗБАХ-ний гүйцэтгэлд ногдох элэгдлийн зардалтай холбоотой.
12. Даатгалын зардал 130.4 сая төгрөгөөр буурсан нь үе шаттайгаар даатгал хийгдэж байгаатай холбоотой.
13. Бусад зардал 262.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс буурсан нь төлөвлөгдөөгүй зардлын хэмнэлт гарсан байна.

ДӨРӨВ. УДИРДЛАГЫН ЗАРДЛЫН ТАЛААР

Удирдлагын үйл ажиллагааны зардлуудаас цалин 35.4 сая төгрөг, НДШ 21.9 сая төгрөг, албан томилолт 3.3 сая төгрөг, сургалт 1.9 сая төгрөг, шатахуун тос 155.8 мянган төгрөг, 1.8 сая харуул хамгаалалт төгрөг, холбоо бичиг хэрэг 13.5 сая төгрөг, ТУЗ-ийн зардал 4.5 сая төгрөг, гишүүний байгууллагын татвар 2.0 сая төгрөг тус тус хэмнэж дүнгээрээ 84.5 сая төгрөгөөр, лицензийн түрээс 48.0 сая төгрөг, аудит, найдваргүй авлагын зардал, засвар үйлчилгээ бусад зардал 110.8 сая төгрөгөөр удирдлагын хөдөлмөр хамгаалалын зардал 7.7 сая төгрөг, цахилгаан 17.3 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 3.4 сая төгрөг,

дулаан цэвэр бохир ус 576.1 мянган төгрөгөөр тус тус хэтэрч дүнгээрээ 187.9 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт дүнгээрээ 103.4 сая төгрөгөөр буурсан байна.

Бусад зардал 110.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аудитын хөлс 33.6 сая төгрөг, зээл олголтын шимтгэлд 24.0 сая төгрөг, усны геофизикийн ажлын хөлс 12.8 сая төгрөг, ОШМИ стандартын ажлын хөлс 12.4 сая төгрөг гэх мэт зардлуудтай холбоотой.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 48.0 хувь буюу 455.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэлийн бус үйл ажиллагааны орлого төлөвлөсөн хэмжээнээс 1305.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгө борлуулсаны орлого 1519.0 сая төгрөгтэй холбоотой.

Үйлдвэрлэлийн бус үйл ажиллагааны зардал 2211.7 сая төгрөгөөр өссөн нь урт хугацаат болон богино хугацаат зээлийн хүүгийн зардал 564.9 сая төгрөг, үндсэн хөрөнгө борлуулсаны алдагдал 1619.1 сая төгрөг гол нөлөөлж байна.

Үйлдвэрлэлийн бус үйл ажиллагааны алдагдал төлөвлөсөн хэмжээнээс 906.2 сая төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеийнхээс 272.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдлээ.

ТАВ. Үйл ажиллагааны үр дүнгийн талаар

2016 оны эхний хагас жилд бизнес төлөвлөгөөгөөр нийт 20,294.5 сая төгрөгийн борлуулалт хийж 22,356.3 сая төгрөгийн зардал гарган 2061.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн юм.

2016 оны эхний хагас жилд үндсэн үйл ажиллагаанаас 18,845.5 сая төгрөгийн орлого олж 18,306.3 сая төгрөгийн зардал гарган 539.2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, үүнээс үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанаас 1632.4 сая төгрөгийн орлого олж 2647.9 сая төгрөгийн зардал гарган 1015.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллан, нийт дүнгээрээ 476.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаа.

Үйлдвэрлэлийн төлөвлөгөөт алдагдал 1585.5 сая төгрөгөөр буурсан нь үйлдвэрлэлийн голлох зардлууд болох тэсрэх материал, дизель түлшний зардал, цахилгааны зардлын бууралттай холбоотой.

Мөн нүүрс борлуулалтын төлөвлөгөө 36.0 м.тн –оор дутаж, борлуулалтын орлого 1402.1 сая төгрөгөөр буурсан байна.

Техник-эдийн засгийн үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

ЗУРГАА. Авлага, өглөгийн талаар

ДОЛОО. Санхүүгийн тайлангийн шинжилгээний дүгнэлт

Санхүүгийн тайлангийн шинжилгээ нь ААН-ийн үйл ажиллагааны санхүүгийн тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж бизнесийн байгууллагын өнөөгийн болон ойрын ирээдүйн санхүүгийн байдлыг тодорхойлж, дүгнэлт өгөхөд оршино.

“Шивээ-Овоо” ТӨХК төвийн болон орон нутгийн шинж чанартай станцуудад дулаан, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн түүхий эд материал болох хүрэн нүүрсийг олборлон нийлүүлдэг. Үйл ажиллагааны хувьд 365 хоног тасралтгүй явагддаг онцлогтой. Санхүүгийн шинжилгээг 2012-2016 онуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийж санхүүгийн хүндрэлд орж буй эсэх, цаашид авч хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлоход шинжилгээний гол зорилго оршино. Тус компани бүтээгдэхүүний өртгөөс доогуур үнээр бүтээгдэхүүнийг худалдан борлуулдаг болно.

Товч дүгнэлт

“ШИВЭЭ-ОВОО”ХК-ий эдийн засгийн чадавхийг тодорхойлох зорилгоор 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангын үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж дараах дүгнэлтэнд хүрлээ.

1. Сүүлийн 5 жилийн хугацаанд компанийн нийт хөрөнгийн хэмжээ жилд 3 хувь, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ жилд 50 хувиар тус тус өсөж, урт хугацаат өр төлбөрийн дүн жилд 8 хувиар буурсан бол нийт өр төлбөрийн дүн жилд 8 хувиар өссөн дүнтэй байна.
2. Төлбөрийн чадварын шинжилгээний үзүүлэлтүүд буурч байгаа нь богино хугацаат Ө.Т-ийг барагдуулах төлбөрийн чадваргүй болж байгааг илэрхийлж байна.
3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний үзүүлэлтүүдийн өөрчлөлт харилцан адилгүй байна. Үүнд: Бие даах чадварын коэффициент 0.04 нэгжээр буурч байгаа нь гадны эх үүсвэрээс хараат бусаар, өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадвар буурч байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн хувьд тогтворгүй байдал бий болсоныг илэрхийлж байна. Нөгөөтэйгүүр бие даах чадвар багасч санхүүгийн хамаарал нэмэгдэж байгаа нь цаашдын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.
4. Мөнгөн урсгалын шинжилгээний үзүүлэлтүүдийн өөрчлөлт харилцан адилгүй байгаагаас харахад байгууллагын ойрын санхүү төлбөрийн чадварыг сайжруулах хэрэгтэй байгааг илтгэж байна.
5. Ашигт ажиллагааны шинжилгээний үзүүлэлтүүд дотроос борлуулалтын ашигт ажиллагаа нэмэгдэж хөрөнгө болон эздийн өмчийн ашигт ажиллагаа буурсан байна.
6. Альтманы индекс сүүлийн 5-н жил дэх хамгийн өндөр түвшинд хүрч компаний үйл ажиллагаа цаашдаа тогтвортой явагдах боломж, хэтийн төлөв харагдаж байна.
7. Эргэцийн шинжилгээний үзүүлэлтүүд сүүлийн 5-н жилийн дундажаар өсөлттэй байгаа нь эргэлтийн хөрөнгийн нэг хэлбэрээс нөгөөд шилжих хөдөлгөөн удаан байгааг илэрхийлж байна. Эргэц удааширахын хэрээр үйлдвэрлэлийн үр ашиг буурдаг. Авлага барагдуулах хугацаа буюу авлагын эргэц (удаа) сүүлийн 5-н жилд дундажаар 33 хувиар өссөн байгаа нь найдвартай хэрэглэгчдийн тоо буурсантай холбоотой. Бусад эргэцийн

үзүүлэлтүүд 20 хүртэлх хувиар өссөн нь зохистой харьцаа алдагдсан байгааг харуулж байна.

8. Бүтээмжийн шинжилгээний үзүүлэлтүүд өсөлттэй байгаа нь цаашдын хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, үйл ажиллагаа тогтвортой өсөхийг илтгэж байна.

Дэлгэрэнгүй дүгнэлт

Төлбөрийн чадварын шинжилгээ:

Тус шинжилгээний гол зорилго нь тухайн компани санхүүгийн хүндрэл, дампууралд орж болзошгүй байдлыг урьдчилан тодорхойлох явдал. Судалгааны үр дүнгээр төлбөрийн чадварын шинжилгээний үзүүлэлтүүд зохистой байх хэмжээнээс доогуур байгаа нь салбарын нийт өр төлбөрийн ихэнх хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл богино хугацаат өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай санхүүгийн нөөц хүрэлцээгүй байна.

Эргэлтийн хөрөнгийн харьцаа буюу богино хугацаат өр төлбөрт ноогдох хөрөнгийн дүн жилд 25 хувийн бууралт үзүүлж, зохистой түвшнөөс бага байгаа нь богино хугацаат Ө.Т-ийг барагдуулах төлбөрийн чадваргүй байгааг илэрхийлнэ. 2012 онд зохистой хэмжээнд байсан тус харьцаа сүүлийн 5 жилд тогтмол буурсан үзүүлэлттэй байна. Эндээс дүгнэж хэлэхэд 2012 онд БХӨТ нь эргэлтийн хөрөнгөөр баталгаажих чадвартай байсан бол 2016 онд баталгаажих чадвар 77.7 хувиар буурч чадваргүй түвшинд хүрсэн байна. Шалтгаан нь богино хугацаат өр төлбөр нэмэгдсэн явдал.

Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа зохистой байх хэмжээнээс доогуур байгаа нь түргэн хөрвөх хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах боломжгүй байгааг илэрхийлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд тус харьцаа тогтмол буурсан нь БХӨТ-ийн хэмжээ тогтмол өссөнтэй холбоотой. Тус харьцаа сүүлийн жилүүдэд буурч жилд дундажаар 28 хувийн бууралтыг бодитоор үзүүлсэнээр компанийн бэлэн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө багассаныг харуулж байна. Одоо бэлэн байгаа мөнгөн хөрөнгө болон бүрэн цугларсан авлагаар хүлээгдэж байгаа өглөгийн 6 хувийг төлж чадахаар байна. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ сүүлийн 5-н жил дэх хамгийн доод түвшиндээ хүрч өнгөрсөн оны мөн үеэс 67 хувиар буурсан нь нийт авлагын хэмжээ буурсантай холбоотой.

Цэвэр эргэлтийн хөрөнгө сүүлийн 3-н жилд сөрөг утгатай байгаа нь богино хугацаат өр төлбөрийн хэмжээ нийт эргэлтийн хөрөнгөнөөс их байгааг илэрхийлж байна. Тодруулвал, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ жилд 50 хувиар өсөж буйтай холбоотой. Сүүлийн 5 жилд цэвэр эргэлтийн хөрөнгийн хэмжээ тогтмол буурсан нь БХӨТ-ийн хэмжээ тогтмол өссөнтэй холбоотой.

Эргэлтийн хөрөнгийн хувийн жингээс харахад нийт эргэлтийн хөрөнгө нийт хөрөнгөний 20 хувийг бүрдүүлж байгаа бол нийт өр төлбөрийн 50 хувийг богино хугацаат өр төлбөр бүрдүүлж байна. Сүүлийн 5н жилийн хугацаанд эргэлтийн хөрөнгийн хувийн жин тогтмол үзүүлэлттэй байгаа бол төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин тогтмол өсөлттэй байгаа нь БХӨТ-ийн дүн тогтмол нэмэгдсэнтэй холбоотой.

Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ:

Богино хугацаанд санхүүгийн байдал нь төлбөрийн чадвараар хэмжигддэг. Урт хугацаанд санхүүгийн байдал нь байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлаас шалтгаалдаг. Бие даах чадварын үзүүлэлт жилд дундажаар 25 хувиар буурч, санхүүгийн хамаарлын үзүүлэлт 39 хувиар нэмэгдсэнээс үзэхэд компанийн санхүүгийн байдал хүндэрч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны найдвартай ажиллагаа алдагдсаныг харуулж байна.

Бие даах чадварын коэффициент зохистой хэмжээнээс бага байгаа нь гадны эх үүсвэрээс хараат бусаар, зөвхөн өөрийн санхүүжилтээр биеэ дааж үйл ажиллагаагаа явуулах чадвар бага байгааг илэрхийлнэ. Өөрийн капиталын оролцоо их байх тусам үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрддэг. Нийт хөрөнгийн 4 хувийг өөрийн хөрөнгө эзэлж байна. Сүүлийн 5-н жилийн хугацаанд тус коэффициент тогтмол буурсан нь эздийн өмч тогтмол буурч нийт хөрөнгийн дүн тогтмол өссөнтэй холбоотой. Харин **Санхүүгийн хамаарлын коэффициент** зохистой хэмжээнээс их байгаа нь нийт эх үүсвэрт гадны капиталын эзлэх хувийн жин их байгааг илтгэнэ. Сүүлийн 5-н жилд тогтмол өсөлттэй гарсан нь өөрийн хөрөнгийн хэмжээ буурсантай холбоотой.

Зохицуулалтын коэффициент зохистой хэмжээнээс бага байгаа нь өөрийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ буурсантай холбоотой. **Өөрийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ** сөрөг утгатай байгаа нь үндсэн хөрөнгийн хэмжээ их байгаатай холбоотой.

Өр төлбөрийн хувийн жингээс харахад нийт хөрөнгийн 96 хувьтай тэнцэх хэмжээний өр төлбөртэй байна. Энэ нь тийм сөрөг зүйл биш. Гол нь өр зээлийг зөв удирдан үр ашигтай ашиглах хэрэгтэй. Сүүлийн 5 жилийн хугацаанд тогтмол өсөлттэй гарсан нь нийт өр төлбөрийн хэмжээ тогтмол өссөнтэй холбоотой.

Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа зохистой хэмжээнээс их байгаа нь урт хугацаат зээлийн хэмжээ их байгааг илтгэж байна. Тодруулвал, эздийн өмчөөс 4 дахин их байна. Сүүлийн 4-н жилийн хугацаанд тогтмол өсөж байгаад өнгөрсөн онд буурсан нь урт хугацаат зээл буурсантай холбоотой. Тодруулвал, урт хугацаат зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 69 хувиар буурсан байна.

Мөнгөн урсгалын шинжилгээ:

Байгууллагын санхүү төлбөрийн чадварын өнөөгийн байдал, хэтийн төлөвийг тодорхойлж үнэлэлт өгөхөд мөнгөн урсгалын шинжилгээ чухал мэдээллийг багтаадаг. Гол зорилго нь мөнгөний орох, гарах урсгалын нийлбэр дүнгээр ирээдүйн төсөв бэлтгэх явдал юм. Цэвэр эргэлтийн хөрөнгийн борлуулалт болон нийт хөрөнгөтэй харьцах харьцаа бууралттай байгаа нь цэвэр эргэлтийн хөрөнгийн хэмжээ буурч богино хугацаат өр төлбөрийн хэмжээ өссөнтэй холбоотой.

Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа жилд 13 хувийн өсөлттэй байгаа нь мөнгөн орлогын хэмжээ өссөнтэй холбоотой бол мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа жилд 13 хувиар өсч үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн борлуулалтын өртөгөөс давсан үзүүлэлттэй байна.

Ашигт ажиллагааны шинжилгээ:

Ашигт ажиллагааны шинжилгээ нь ААН-үүд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эдийн засгийн нөөцүүд болон эх үүсвэрүүд нь хэрхэн үр өгөөжтэй зарцуулагдаж байгаа байдалд үнэлгээ дүгнэлт хийдэг. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа

явуулдаг ААН-үүд өндөр үнэтэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаас шалтгаалж эхний жилүүдэд алдагдалтай ажиллаж байгаад аажмаар ашигтай ажиллах төлөвтэй байдаг. Үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг өртгөөс доогуур үнээр борлуулж байгаатай холбоотой ашигт ажиллагааны бүх үзүүлэлт хангалтгүй байдаг болно.

Борлуулалтын ашигт ажиллагаа нь борлуулалтын нэгж тутамд хэдэн төгрөгийн ашиг олж байгааг харуулахын зэрэгцээ борлуулалтын хэдэн хувьтай тэнцүү ашиг олж байгааг харуулна. Тус үзүүлэлтээс харахад 100 төгрөгний борлуулалтаас 10.3 төгрөгний ашиг буюу нийт борлуулалтын 10.3 хувьтай тэнцүү хэмжээний ашиг олж байгааг илэрхийлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эерэг дүнтэй гарсан нь нийт ашиг эерэг дүнтэй гарсантай холбоотой.

Эздийн өмчийн ашигт ажиллагаа нь ногдол ашгийн хуваарилалт болон бизнесийн ирээдүйн өсөлтийг санхүүжүүлэхийн тулд хамгийн багадаа 14 хувь байх шаардлагатай гэж судлаачид үздэг. Тус үзүүлэлт -11 хувьтай байгаа нь ойрын хугацаанд бизнесийн ирээдүйн өсөлтийг санхүүжүүлэх чадвартай болох боломж бага гэдгийг илэрхийлж байна.

Дампуурлын шинжилгээ:

Альтманы индексээр "Шивээ-Овоо" ХК-ийн эдийн засгийн чадавхид үнэлгээ хийв. Дампуурлын шинжилгээний альтманы индексийн хэмжээ 5.59 гарч байгаагаас харвал үйл ажиллагаа нь хэвийн гэж дүгнэж болохоор байна. Үүнд: борлуулалтын орлогын тогтмол өсөлт, нийт хөрөнгийн өсөлтүүд гол нөлөөг үзүүлж байна. Түүнчлэн тус хэмжээ өндөр гарахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь эздийн өмчийн 90 хувийг төрийн өмч эзэлж байгаатай холбоотой. Ингэснээр дампуурах магадлал тэр хэмжээгээр буурч байна гэсэн үг юм.

Эргэцийн шинжилгээ:

Авлагын эргэц буюу зээлээр борлуулсан борлуулалтын мөнгийг цуглуулах дундаж хугацаа 360 хоногт 6-н удаа буюу 57 хоногт нэг удаагийн эргэц хийж байгаа нь хангалттай үзүүлэлт биш боловч өнгөрсөн онтой харьцуулахад нэг удаагийн авлага авах дундаж хугацаа 99 хоногоор буурсан үзүүлэлттэй байна. Хугацаа өндөр байх тусам эргэц удаан байна, эргэц хурдан байх зохимжтой.

БМ-ын нөөцийн эргэц түргэсэхийн хирээр борлуулалт сайн хийгдэж мөнгөн орлого нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлнэ. БМ-ын эргэц 360 хоногт 1.4-н удаа буюу 249 хоногт нэг удаа БМ солигдож байгаа нь сайн үзүүлэлт биш юм. Энэ нь БМ-ын эргэц удаан байгааг илтгэж байна.

Ерөнхийдөө тус эргэцийн шинжилгээнээс дүгнэж хэлэхэд эргэцийн давтамж бага, хугацаа өндөр, эргэц удаан байна.

Бүтээмжийн шинжилгээ:

Хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлт сүүлийн 5-н жилд дундажаар 4 хувиар өсөж байгаа нь ажлын бага хүчээр боломжит бүтээмжтэй ажиллаж байгааг илтгэж байгаа бол Эдийн засгийн тогтвортой байдал өнгөрсөн 2 жилд дундажаар 40 хувиар нэмэгдсэн нь цаашдаа эдийн засгийн хувьд тогтвортой өсөлт бий болохыг илтгэж байна.

Сайжруулах арга зам болоод гарах үр дүн

“Шивээ-Овоо” ХК-ийн нийт хөрөнгийн хэмжээ жилд дундажаар 3 хувийн өсөлтийг харуулж, богино хугацаат өр төлбөрийн хэмжээ жил бүр 50 хувиар өсөж, санхүүгийн хараат байдлын үзүүлэлт 39 хувиар өссөн байгаагаас дүгнэж үзвэл найдвартай хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, үнийг чөлөөлж, шинэ зах зээлд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, мөнгөний урсгалыг зөв удирдан зохион байгуулах, авлага, эргэлтийн хөрөнгө, бараа материалын эргэцийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

НАЙМ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Компани алдагдалгүй, ашигтай ажиллая гэвэл санхүүгийн боломжиндоо нийцүүлэн хөрс хуулалтын хэмжээгээ бууруулж, хуримтлагдаад буй хөрс хуулалтын хоцрогдолыг нэмэгдүүлэх сонголт хийхэд хүрч байна.

2016 оны үлдэж буй хугацаанд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллах шаардлагатай байна.

1. 2016 оны эхний хагас жилийн борлуулалтын төлөвлөгөөний тасалдалыг 4-р улиралд нөхөхийн тулд ДЦС-IV ТӨХК, Амгалан ДС-уудад хийхээр төлөвлөсөн борлуулалтын хэмжээгээ 40 мянган тонноор нэмэгдүүлэх
2. 2ш алхагч экскаваторын бүтээлийг нэмэгдүүлэх замаар хөрс хуулалтын ертгийг бууруулах
3. Өмнөх оноос дизель түлшний үнэ харьцангуй хямдарч нийлүүлэгдэж байгаа, уулын техникүүдийн эвдрэлийг шинэ сэлбэгээр бус, бараа материалын складын нөөцөө шавхах, хуучин сэлбэгийг засварлах, сэлбэх зэргээр хэмнэлтийн бодлогоор ажиллаж байна.
4. Шинээр худалдан авсан техник, тоног төхөөрөмжүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар парк ашиглалт, техникийн бэлэн байдалд онцгой анхаарч ажиллаж байна.
5. Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажилчдын хөдөлмөрийн бүтээмж, сахилга хариуцлагыг чангатгах, хөдөлмөр зохион байгуулалтын сайжруулах арга хэмжээг авч байна. Ирэх онуудад орон тоо нэмэгдүүлэхгүй байх, цаашлаад орон тоог бууруулж 1 хүнд ажлын ачааллыг нягтруулж ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай.

"ШИВЭЭ-ОВОО" ХК-ИЙН 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дд.	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2015 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	хувийн жин	2016 оны эхний хагас жилийн төлөвлөгөө	2016 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	нэгж	хувийн жин	Хэлбэлзэл төл-с %	2016 2015 %
А.Уулын ажлын үзүүлэлт										
1	Нүүрс борлуулалт	м.тн	870,2		875,8	839,8			95,9	96,5
2	Нүүрс олборлолт	м.тн	835,3		867,7	846,2			97,5	101,3
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м³	2 290,9		2 213,3	2 782,9			125,7	121,5
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м³	904,1		1 402,3	1 131,6			80,7	125,2
5	дахин шидэлт	м.м³	548,0		818,0	675,7			82,6	123,3
6	Нийт хөрс хуулалт	м.м³	3 195,0		3 615,6	3 914,5			108,3	122,5
7	Инженер ажил	м.м³	671,2		290,0	541,2			186,6	80,6
8	Нийт уулын цул	м.м³	5 104,6		6 058,0	5 830,7			96,2	114,2
Б.Өртөг зардлын үзүүлэлт										
1	Тэсрэх материал	м.төг	1 315 076,7	0,07	1 033 929,7	1 245 235,4	213,6	0,07	120,4	94,7
2	Дизелийн түлш	м.төг	3 097 509,4	0,16	4 111 291,0	2 922 013,39	501,1	0,15	71,1	94,3
3	Бензин	м.төг	39 841,4	0,00	45 795,0	27 792,28	4,8	0,00	60,7	69,8
4	Тос, тослох материал	м.төг	340 645,1	0,02	358 475,5	331 856,89	56,9	0,02	92,6	97,4
5	Цахилгаан	м.төг	1 056 849,3	0,05	1 550 256,2	1 238 586,79	212,4	0,07	79,9	117,2
6	Вагон ашиглалт	м.төг	113 699,6	0,01	114 403,1	75 804,16	13,0	0,00	66,3	66,7
7	Дулаан	м.төг	57 738,1	0,00	45 508,3	41 734,68	7,2	0,00	91,7	72,3
8	Дугуйн зардал	м.төг	383 387,7	0,02	376 940,0	341 503,72	58,6	0,02	90,6	89,1
9	Сэлбэг	м.төг	3 475 713,7	0,18	3 506 192,8	3 796 953,37	651,2	0,20	108,3	109,2
10	Хөдөлмөр хамгаалал	м.төг	176 893,4	0,01	350 991,9	152 377,22	26,1	0,01	43,4	86,1
11	Цалин	м.төг	3 188 434,3	0,16	3 636 459,3	3 483 571,09	597,4	0,18	95,8	109,3
12	НДШ	м.төг	409 714,1	0,02	472 739,7	447 792,46	76,8	0,02	94,7	109,3
13	АМНөөц	м.төг	490 803,6	0,03	499 189,4	471 086,82	80,8	0,02	94,4	96,0
14	ҮХХАТ, УАТ, АТӨЯХАТ	м.төг	402 103,9	0,02	305 725,2	329 726,63	56,5	0,02	107,9	82,0
15	ҮХ-н элэгдэл	м.төг	3 144 032,5	0,16	3 435 388,9	3 134 286,20	537,5	0,17	91,2	99,7
16	Зээлийн хүү	м.төг	314 630,8	0,02				0,00	#DIV/0!	-
17	25/90, мэргэжилтний зардал	м.төг	-	-				0,00	#DIV/0!	#DIV/0!
18	Даатгалын зардал	м.төг	40 666,0	0,00	180 506,7	50 101,91	8,6	0,00	27,8	123,2
19	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	21 135,0	0,00				0,00	#DIV/0!	-
20	Гэрээт ажлын хөлс	м.төг	1 032 274,9	0,05	293 200,0	736 052,52	126,2	0,04	251,0	71,3
21	Бусад зардал	м.төг	288 053,1	0,01	369 756,7	107 417,14	18,4	0,01	29,1	37,3
22	Өөрийн өртөг	м.төг	19 389 202,8	1,00	20 686 749,42	18 933 892,69	3 247	1,00	91,5	97,7
23	Удирдлагын зардал	м.төг	947 859,0	0,05	1 233 306,8	1 402 979,4	241	0,07	113,8	148,0
24	Борлуул өөрийн өртөг	м.төг	18 201 504,8	0,94	21 920 056,2	18 306 290,3	3 140	0,97	83,5	100,6
В. Орлогын үзүүлэлт										
1	Борлуулалтын орлого	м.төг	19 632 365,3		19 967 577,1	18 845 498,9			94,4	96,0
3	Борлуулалтын ашиг	м.төг	1 430 860,4		(1 952 479,1)	539 208,6			(27,6)	37,7
4	Үйл/аж бус орлого	м.төг	1 592 860,4		326 937,5	1 632 440,3			499,3	102,5
5	Үйл/аж бус зардал	м.төг	2 335 907,4		436 210,0	2 647 898,4			607,0	113,4
6	Үйл/аж бус ашиг	м.төг	(743 047,0)		(109 272,5)	(1 015 458,1)			929,3	136,7
7	Татварын өмнөх ашиг	м.төг	687 813,4		(2 061 751,6)	(476 249,6)			23,1	(69,2)
Г.Бусад үзүүлэлт										
1	1 тн нүүрсний өртөг борлуулалт	төг	20 915,5		25 028,6	21 798,2			87,1	104,2
2	1 тн нүүрсний өртөг олборлолт	төг	23 211,8		23 840,9	22 374,5			93,8	96,4
3	1 тн нүүрсний дундаж үнэ	төг	22 559,7		22 799,2	22 440,3			98,4	99,5
4	1м³ уулын цулын өртөг	төг	3 565,7		3 618,4	3 139,6			86,8	88,0
5	Хөрс хуулалтын коэффициент	коэфф	3,8		4,2	4,6			111,0	120,9
6	Ажиллагчдын тоо	хүн	583		595	570			95,8	97,8
7	Нийт цалингийн сан	м.төг	3 701 613,1		4 343 071,6	4 154 827,1			95,7	112,2
8	Сарын дундаж хөлс	м.төг	1 058,2		1 216,5	1 214,9			99,9	114,8
9	Нийт авлага	м.төг	7 864 446,8		6 861 836,9	2 322 451,9			33,8	29,5
10	Нийт өглөг	м.төг	86 315 221		83 672 314,0	92 572 937,8			110,6	107,2
	Богино хугацаат өглөг	м.төг	32 960 060,1		29 960 434,9	50 711 661,2			169,3	153,9
11	Борлуулалтын 1төг-т ногдох зардал	төг	0,93		0,91	1,03			113,0	111,0
12	Төсвийн төлбөрт	м.төг	3 265 858,2		3 274 412,0	3 133 155,8			95,7	95,9
	Үүнээс: а\ ААН-ийн ОАТ	м.төг							#DIV/0!	#DIV/0!
	б\ НӨАТ	м.төг	1 963 236,5		1 996 757,7	1 884 549,9			94,4	96,0
	в\ бусад татварууд	м.төг	1 302 621,7		1 277 654,3	1 248 605,9			97,7	95,9

2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТАЙЛАН

Дд.	Үзүүлэлтүүд	2015 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	2016 оны эхний хагас жилийн төлөвлөгөө	2016 оны эхний хагас жилийн гүйцэтгэл	Хэлбэлз эл төл-с %	2016 2015 %
1	Үндсэн цалин	600 246,7	706 612,3	671 256,0	95,0	111,8
2	Цалингийн шимтгэл	77 715,6	91 859,6	69 881,9	76,1	89,9
3	Цахилгаан	14 026,6	26 511,9	43 845,4	165,4	312,6
4	ҮХ-н элэгдлийн шимтгэл	53 395,7	62 142,8	65 546,0	105,5	122,8
5	Албан томилолт	22 523,9	35 694,7	32 431,0	90,9	144,0
6	Сургалт	10 892,2	26 261,5	24 329,6	92,6	223,4
7	Шатахуун тос	5 550,8	6 856,0	6 700,2	97,7	120,7
8	Дулааны зардал	1 651,9	2 090,0	2 666,1	127,6	161,4
9	Харуул хамгаалалтын зардал	23 989,4	93 000,0	91 222,1	98,1	380,3
10	Холбоо бичиг хэрэг	18 917,0	33 547,0	20 074,5	59,8	106,1
11	Хөдөлмөр хамгаалал	29 105,6	27 135,8	34 867,6	128,5	119,8
12	ТУЗ-ийн зардал	27 505,3	32 066,8	27 554,3	85,9	100,2
13	Маркетинг урамшуулал	1 767,8	-	-	#DIV/0!	-
14	Түрээс / лиценз, УБТГ/	8 287,3	8 100,0	56 100,0	692,6	676,9
15	Гишүүн байгууллагын татвар	-	2 075,0	-	-	#DIV/0!
16	Аудит, НА-зардал, бусад	52 283,2	79 353,5	190 221,6	239,7	363,8
	Дүн	947 859,0	1 233 306,8	1 402 979,4	113,8	148,0

Авлагын талаар

2016 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт авлага 5,3 тэрбум төгрөг болж оны эхнээс 1,0 тэрбум төгрөгөөр буурлаа. Энэ бууралтанд нөлөөлсөн гол хүчин зүйл нь ДЦС-4 ТӨХК-аас авах авлага 1,6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Авлага барагдуулах ажлыг зохион байгуулж Дорноговийн ДС Чандмань илч ХХК-аас авах авлагыг 114,7 сая Налайхын ДС-ын авлагыг 45,0 сая төгрөгөөр бууруулж ажиллаа.

Нийт авлагын 75,5 хувь буюу 4,0 тэрбум төгрөг нь Төрийн болон орон нутгийн өмчит дулааны станцуудаас авах авлага байгаа бол 241,2 сая нь гэрээний урьдчилгаа төлбөр, 500,1 сая төгрөг нь ажилчидаас авах авлага, 292,9 сая төгрөг нь шүүхийн шийдвэртэй ч төлөгдөхгүй удсан авлага байна.

Орон сууцны 12-р байрыг засварлан ашиглалтанд оруулж ажилчиддаа өртгөөр нь буюу метр квадратыг нь 498,2 сая төгрөгөөр худалдсан бөгөөд үүний зарим төлөлтүүд сар дамжин 7-8-р саруудад төлөгдсөн нь ажилчидаас авах авлага 295,5 төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн.

Улсын төсөвт байгууллагуудын халаалтын төлбөр төлөгдөхгүй байна гэсэн нийтлэг шалтгаанаар орон нутгийн өмчит станцууд нүүрсний төлбөрөө гүйцэд төлөхгүй байгаа нь авлага барагдуулалтын гол тулгамдсан асуудал боллоо.

Энэ талаар холбогдох байгууллагуудад удаа дараа бичгээр мэдэгдэж, эрх бүхий албан тушаалтнууд биечлэн очиж нэхэмжилсэн боловч төлбөр төлөгдөхгүй хэвээр байна.

Дорноговь, Говьсүмбэр Налайх, Зүүнхараа зэрэг газруудын дулааны станцуудаас авлагаа нэхэмжлэн алданги тооцож шүүхэд хандахаа мэдэгдсэн бичгийг илгээсэн бөгөөд шүүхэд шилжүүлэхээр холбогдох баримтуудыг бэлтгээд байгаа болно.

Авлагын үлдэгдэл шалтгаан өөрчлөлтийг дэлгэрэнгүй тусгасан хүснэгтийг хавсаргав.

Богино хугацаат өглөгийн талаар

2016 оны эхний хагас жилийн байдлаар компанийн богино хугацаат өглөг 50,8 тэрбум төгрөг болж оны эхнээс 1,4 тэрбум төгрөгөөр өслөө. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан техникийн шинэчлэлд зориулж 2,4 тэрбум төгрөгийн зээл авсан нь энэ өсөлтөнд нөлөөлсөн гол хүчин зүйл боллоо.

Өнгөрсөн 2015 оны томоохон худалдан авалтаар үүссэн өглөгүүдийг барагдуулах бодлого баримтлан ажиллаж эдгээр өглөгийг 1,6 тэрбумаар бууруулаад байгаа

бөгөөд одоо 2,3 тэрбум төгрөг үлдээд байна. Мөн 2,2 тэрбум төгрөгийн арилжааны банкны зээлийн үлдэгдэлээ төлж барагдуулсан.

Хүүтэй зээлийн үлдэгдэлээ аль болох багасгах талаар анхаарч 2,4 тэрбум төгрөгийн зээлийнхээ 550 саяыг нь төлсөн.

Энэ мэтчилэн богино хугацаат өр төлбөрийг барагдуулсаар байгаа боловч 2016 оны сонгон шалгаруулалтын сэлбэг материал нийлүүлэлт хийгдэж шинээр өглөгүүд үүссээр байна.

Богино хугацаат өглөг жилээс жилд ингэж нэмэгддэг гол шалтгаан нь техникийн шинэчлэлд зориулсан хөрөнгийн эх үүсвэр байдаггүйтэй шууд холбоотой. Хэдийгээр эх үүсвэр байхгүй ч шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үүсч урсгал зардалд зарцуулах мөнгөн хөрөнгөө хөрөнгө оруулалтанд зарцуулж урсгал зардлаа өглөг үүсгэн санхүүжүүлж байна.

Богино хугацаат өглөг 50,8 тэрбумын 50 хувь нь 1998-2003 онуудад хийгдсэн зээлийн хөрөнгө оруулалтын хугацаа хэтэрсэн төлбөр, 10,0 хувь нь Толгой компанидаа төлөх өглөг байгаа бөгөөд эдгээрийг хөнгөлөх, чөлөөлүүлэх хүсэлтийг бид төр засгийн түвшинд удаа дараа тавьсаар байгаа юм.

Энэ 2 өглөгийг хасаад үлдэж байгаа 20,6 тэрбум төгрөгийн өрийн 4,2 тэрбум нь хаалт хийгдэхээр ЗГ-ын шийдвэр гарсан түлшний өглөг, 1,9 тэрбум нь арилжааны банкны зээл, 3,3 тэрбум нь санхүүгийн түрээсийн өглөг, 1,5 тэрбум нь татвар, НДШ-н өглөг байна.

Эдгээрээс гадна үлдэж байгаа 7,8 тэрбум төгрөгийн өглөгийн 2,3 тэрбум өнгөрсөн жилийн тендерийн худалдан авалтуудын хугацаа хэтэрсэн өглөг бусад 5,5 тэрбум нь 1 жилээс дотогш үүссэн өглөгүүд байгаа юм.

Авлагын үлдэгдэл, өөрчлөлт, ангилал

Д/д	Харилцагчийн нэр	Үлдэгдэл		Үүнээс				Өөрчлөлт		
		Оны эхэнд	6-р сарын 30	Нүүрсний авлага	Шүүхийн шийд	Урьдчилгаа төл	Бусад	Нэмэгдсэн	Буурсан	Хувь
1	Улаанбаатар ТЭЦ-4	3 819 393,2	2 137 673,5	2 137 673,5	0,0	0,0	0,0	0,0	-1 681 719,7	- 44,0
2	Бор Өндөрийн үйлдвэр	254 919,8	888 418,8	888 418,8	0,0	0,0	0,0	633 499,0	0,0	248,5
3	Чандмань илч Дорноговь	447 793,7	333 032,3	333 032,3	0,0	0,0	0,0	0,0	-114 761,5	- 25,6
4	Энэрэлт Ээж ХХК	248 815,7	248 815,7	0,0	248 815,7	0,0	0,0	0,0	0,0	-
5	Налайх дулааны станц	250 623,6	205 623,6	205 623,6	0,0	0,0	0,0	0,0	-45 000,0	- 18,0
6	Төмөр замын Удирдах Газар	4 724,3	123 539,6	123 539,6	0,0	0,0	0,0	118 815,3	0,0	2 515,0
7	Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨҮГ	69 650,6	76 972,7	76 972,7	0,0	0,0	0,0	7 322,0	0,0	10,5
8	Ус-Ду ХК	17 884,0	71 975,0	71 975,0	0,0	0,0	0,0	54 091,0	0,0	302,5
9	Эрдэнэ-Эх ХХК	0,0	50 000,0	0,0	0,0	50 000,0	0,0	50 000,0	0,0	100,0
10	Ханын материал Холд	44 087,3	44 087,3	0,0	44 087,3	0,0	0,0	0,0	0,0	-
11	Тахилт зул ХХК	47 656,3	36 333,6	36 333,6	0,0	0,0	0,0	0,0	-11 322,7	- 23,8
12	Монполимет ХХК	0,0	35 000,0	0,0	0,0	35 000,0	0,0	35 000,0	0,0	100,0
13	Подраз ххк	0,0	30 000,0	0,0	0,0	30 000,0	0,0	30 000,0	0,0	100,0
14	Элбэг дулаан ХХК	10 237,6	29 695,6	29 695,6	0,0	0,0	0,0	19 458,1	0,0	190,1
15	Монголын Конвейерын Тээвэр	0,0	23 075,0	0,0	0,0	23 075,0	0,0	23 075,0	0,0	100,0
16	Сүмбэр буянт ХХК	11 614,1	22 907,6	22 907,6	0,0	0,0	0,0	11 293,5	0,0	97,2
17	Сэлэнгэ тэнгэр хараа ХХК	420,8	22 228,7	22 228,7	0,0	0,0	0,0	21 808,0	0,0	5 183,1
18	Цагийн аяс ХХК Налайх	20 454,1	20 454,1	20 454,1	0,0	0,0	0,0	0,0	0,0	-
19	Голден Пэйж Аудит ХХК	0,0	19 600,0	0,0	0,0	19 600,0	0,0	19 600,0	0,0	100,0
20	Мобиком ХХК	15 305,4	18 587,7	0,0	0,0	0,0	18 587,7	3 282,3	0,0	21,4
21	Баянгол сумын ЗДТГ/Сэлэнгэ а	23 250,3	18 250,3	18 250,3	0,0	0,0	0,0	0,0	-5 000,0	- 21,5
22	Квартит ХХК	17 196,9	17 196,9	0,0	0,0	17 196,9	0,0	0,0	0,0	-
23	Усу-Коал ХХК	15 656,2	16 523,3	0,0	0,0	0,0	16 523,3	867,1	0,0	5,5
24	Байгаль Орчны Яам	16 400,0	16 400,0	0,0	0,0	16 400,0	0,0	0,0	0,0	-
25	Ариунбилгүүн ХХК	0,0	15 988,4	0,0	0,0	15 988,4	0,0	15 988,4	0,0	100,0
26	Мегалайн ХХК	15 950,0	15 950,0	0,0	0,0	0,0	15 950,0	0,0	0,0	-
27	Камминс Монголиа Инвестмент	6 880,9	15 720,5	0,0	0,0	15 720,5	0,0	8 839,6	0,0	128,5
28	Монгаз ойл ХХК	15 489,3	15 489,3	15 489,3	0,0	0,0	0,0	0,0	0,0	-

Д/д	Харилцагчийн нэр	Үлдэгдэл		Үүнээс				Өөрчлөлт		
		Оны эхэнд	6-р сарын 30	Нүүрсний авлага	Шүүхийн шийд	Урьдчилгаа төл	Бусад	Нэмэгдсэн	Буурсан	Хувь
29	Илчлэг Шивээ ОНӨҮГ	19 950,5	13 845,1	13 845,1	0,0	0,0	0,0	0,0	-6 105,4	30,6
30	Юнитель ХХК	4 909,8	11 989,8	0,0	0,0	11 989,8	0,0	7 080,0	0,0	144,2
31	Сэлэнгэ гурванбулаг ХХК	10 000,0	10 000,0	10 000,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	-
32	Толика ХХК	0,0	8 292,6	0,0	0,0	0,0	8 292,6	8 292,6	0,0	100,0
33	Төсөвт байгууллагын өрийн орло	0,0	8 095,6	8 095,6	0,0	0,0	0,0	8 095,6	0,0	100,0
34	Ногоон хайрцаг ХХК	0,0	6 686,2	6 686,2	0,0	0,0	0,0	6 686,2	0,0	100,0
35	Хос үржин ХХК	0,0	6 597,0	0,0	0,0	6 597,0	0,0	6 597,0	0,0	100,0
36	Сухайт Хайрхан ХХК	0,0	5 977,5	0,0	0,0	0,0	5 977,5	5 977,5	0,0	100,0
37	Гангар инвест ХХК	5 878,8	5 878,8	5 878,8	0,0	0,0	0,0	0,0	0,0	-
38	Билгүүн орд ХХК	5 588,1	5 588,1	0,0	0,0	0,0	5 588,1	0,0	0,0	-
39	Агь Од ХХК	4 847,7	4 847,7	4 847,7	0,0	0,0	0,0	0,0	0,0	-
40	Чандмань бадрал ХХК	98 854,6	4 626,2	4 626,2	0,0	0,0	0,0	0,0	-94 228,5	95,3
41	Баянжаргалан сум ЗДТГ Ду	788,8	4 091,4	4 091,4	0,0	0,0	0,0	3 302,5	0,0	418,7
42	Дэнжийн өндөр ХХК	5 610,5	3 766,5	3 766,5	0,0	0,0	0,0	0,0	-1 844,1	32,9
43	Өсөх Ирээдүй Трейд ХХК	0,0	3 421,0	0,0	0,0	0,0	3 421,0	3 421,0	0,0	100,0
44	Легион дриллинг ХХК	2 906,2	2 906,2	2 906,2	0,0	0,0	0,0	0,0	0,0	-
45	Бусад байгууллага	29 623,1	35 635,7	0,0	0,0	0,0	35 635,7	6 012,6	0,0	20,3
	Ажилчид	204 710,6	500 593,6				500 593,6	295 883,0		144,5
	Хувь хүмүүс	25051,6	98516,8				98 516,8	73 465,2	0,0	293,3
								0,0	0,0	
	Нийт авлага	6 322 715,87	5 308 957,37	4 067 338,2	292 903,0	241 567,6	709 086,3	0	-1 013 758,5	16,0
	Найдваргүй авлагын нөөц	3 191 012,97	3 191 012,97					0,0	0,0	-
	Цэвэр авлага	3 131 702,90	2 117 944,40					0	-1 013 758,5	32,4
								0,0		

Богино хугацаат өглөгийн үлдэгдэл, өөрчлөлт, ангилал

Д/д	Харилцагчдийн нэр	Үлдэгдэл		Өөрчлөлт		Хувь
		Оны эхэнд	6-р сарын 30	Өссөн	Буурсан	
1	Сангийн Яам зээл зээлийн хүү	23 163 246,34	25 274 394,87	2 111 148,53		9,1
2	Арилжааны банкны зээл	2 216 666,67	1 910 000,00		- 306 666,67	- 13,8
3	Татварын өглөг	787 797,87	738 698,23		- 49 099,63	- 6,2
4	НДШ-ийн өглөг	661 224,32	726 034,08	64 809,76		9,8
5	Санхүүгийн түрээсийн өглөг	425 286,23	302 809,01		- 122 477,22	- 28,8
6	Холбоотой талын өглөг	4 827 491,14	4 965 311,14	137 820,00		2,9
7	Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	2 224 930,23	2 071 344,43		- 153 585,80	- 6,9
8	Цалингийн өглөг	245 529,49	350 645,70	105 116,22		42,8
9	Сод монгол групп ХХК	1 979 557,25	3 132 061,95	1 152 504,70		58,2
10	Тех индустрия ООО	710 671,04	922 363,36	211 692,32		29,8
11	М ойл групп ХХК	-	844 493,00	844 493,00		100,0
12	Эбердигм Монгол	185 993,07	728 402,47	542 409,40		291,6
13	Транс Техно Маркет ХХК	902 377,51	519 733,27		- 382 644,24	- 42,4
14	ЭСТО ХХК	817 616,14	390 112,48		- 427 503,66	- 52,3
15	Преспективе майнинг ХХК	20 642,00	267 442,00	246 800,00		1 195,6
16	МБДЖ	466 468,10	266 775,60		- 199 692,50	- 42,8
17	Хөх өндөр уул ХХК	-	259 751,40	259 751,40		100,0
18	Комит сервис ХХК	249 699,42	257 761,69	8 062,28		3,2
19	Оргил Таур ХХК	1 542 880,20	248 633,54		- 1 294 246,65	- 83,9
20	НИК ХХК	297 225,49	247 220,46		- 50 005,03	- 16,8
21	Очир-Ундраа ХХК	458 292,01	236 970,51		- 221 321,50	- 48,3
22	Мера ХХК	245 052,06	234 544,38		- 10 507,68	- 4,3
23	Хазаарбат ХХК	44 253,34	197 253,33	152 999,99		345,7
24	Универсалжойнт ХХК	148 459,67	188 848,32	40 388,65		27,2
25	Пауэр бласт ХХК	-	165 892,46	165 892,46		100,0
27	Уул уурхайн хүрээлэн	128 448,07	128 448,07	-		-
28	Эс Эл Эс Беарингс Монголиа ХХК	215 574,51	124 321,14		- 91 253,37	- 42,3
29	Глобал Марк Трейдинг ХХК	102 998,44	116 564,44	13 566,00		13,2
30	Юни автосервис ХХК	28 189,57	116 169,91	87 980,34		312,1
31	Интер стандарт нефть ХХК	-	88 551,09	88 551,09		100,0
32	Монничикон трейд ХХК	9 683,48	83 542,08	73 858,60		762,7
33	Ооками ХХК	340 840,84	83 188,05		- 257 652,79	- 75,6
34	Монпетекс ХХК	77 814,33	77 814,33	-		-
35	Стири Стила ХХК	78 809,92	75 641,30		- 3 168,62	- 4,0
36	Сиби Энержи Монгол Групп ХХК	34 363,56	72 133,15	37 769,59		109,9
37	Нитро Сибирь Монголиа ХХК	52 520,00	67 570,80	15 050,80		28,7
38	Алхагч ЭШ ХХК	4 727,45	56 007,46	51 280,00		1 084,7
39	Юнитра ХХК	495,00	50 125,00	49 630,00		100,0
40	Соло-Андууш ХХК	-	49 962,00	49 962,00		100,0
41	Энхгурвал ХХК	-	46 744,00	46 744,00		100,0
42	Ар баянгол ХХК	-	43 117,64	43 117,64		100,0
43	BB and L ХХК	-	43 065,00	43 065,00		100,0

Д/д	Харилцагчдийн нэр	Үлдэгдэл		Өөрчлөлт		
		Оны эхэнд	6-р сарын 30	Өссөн	Бүүрсэн	Хувь
44	Бүрд уул ХХК	44 337,04	40 778,89		- 3 558,15	- 8,0
45	Трансвест ХХК	5 550,69	38 295,64	32 744,95		589,9
46	Монквинта ХХК	-	38 092,99	38 092,99		100,0
47	Гайхам ХХК	32 625,43	35 317,17	2 691,74		8,3
48	Юнайтед белаз машинери ХХК	-	33 263,57	33 263,57		100,0
49	Акума эрин ХХК	232 558,86	32 558,86		- 200 000,00	- 86,0
50	Синчи Ойл ХХК	443 351,55	30 351,55		- 413 000,00	- 93,2
51	Цэнгэг орхон ХХК	-	30 166,76	30 166,76		100,0
52	Ти Өү Би ХХК	-	29 403,11	29 403,11		100,0
53	Багануур ХК	28 229,11	28 229,11	-		-
54	Азиа майнинг солюшн ХХК	28 000,00	28 000,00	-		-
55	Шасси бүрдэлт ХХК	40 227,91	25 428,34		- 14 799,57	- 36,8
56	Дээд ноён хонгор ХХК	41 327,32	24 361,86		- 16 965,46	- 41,1
57	Эс Өү Фаст Би ХХК	12 400,00	20 638,50	8 238,50		66,4
58	Пиртек Монголиа ХХК	10 164,80	19 742,85	9 578,05		94,2
59	Оюун билгүүн од ХХК	-	18 654,66	18 654,66		100,0
60	Шивээ сервис ХХК	-	18 633,30	18 633,30		100,0
61	СЖЦ ХХК	68 189,09	18 239,09		- 49 950,00	- 73,3
62	Энхгурвал ХХК	-	18 150,00	18 150,00		100,0
63	Вагнер ази ТТ ХК	60 374,19	16 569,12		- 43 805,07	- 72,6
64	Сор сонголт ХХК	-	15 797,40	15 797,40		100,0
65	Соёмбот Оргил ХХК	15 120,00	15 120,00	-		-
66	Их Хөтөл ус ХХК	-	11 828,79	11 828,79		100,0
67	Хомын тал ХХК	-	11 425,78	11 425,78		100,0
68	Пазл ХХК	101 200,00	11 200,00		- 90 000,00	- 88,9
69	TAIYAN SHUANGUA HEAVY MASH	10 681,66	10 681,66		-	-
70	Петротрак ХХК	11 388,89	10 551,26		- 837,63	- 7,4
71	Лайнконстракшн ХХК	-	10 450,00	10 450,00		100,0
72	Протек ХХК	8 213,30	10 003,36	1 790,06		21,8
73	ГСА Өмч хувьчлалын орлого	20 000,00	10 000,00		- 10 000,00	- 50,0
74	Хотол дэгжих ХХК	9 900,00	9 900,00	-		-
75	Фоур Галакси Трейдинг ХХК	-	9 680,00	9 680,00		100,0
76	Төрийн банк	23 086,19	9 240,94		- 13 845,25	- 60,0
77	Хаан дөл ХХК	18 816,69	9 080,33		- 9 736,37	- 51,7
78	Баян ач ундарга ХХК	-	8 711,79	8 711,79		100,0
79	Нисээч интернэшнл ХХК	19 411,60	8 451,00		- 10 960,60	- 56,5
80	Есүүдийн Батууд ХХК	-	8 250,00	8 250,00		100,0
81	ХЭМС төв	7 803,50	7 803,50	-		-
82	Чойр Нийгмийн даатгал	8 789,38	7 583,20		- 1 206,18	- 13,7
83	Номбест ХХК	7 000,00	7 000,00	-		-
84	Чармбит хайтеч ХХК	6 630,00	6 630,00	-		-
85	Уран Шивээ ХХК	-	6 566,48	6 566,48		100,0
86	Очсор ХХК	6 315,24	6 315,24	-		-
87	Өсөлт ХХК	6 050,00	6 050,00	-		-
88	МонФарм трейд ХХК	1 566,30	5 951,03	4 384,73		279,9

Д/д	Харилцагчдийн нэр	Үлдэгдэл		Өөрчлөлт		
		Оны эхэнд	6-р сарын 30	Өссөн	Буурсан	Хувь
89	Ногоон шинэс ХХК	-	5 929,04	5 929,04		100,0
90	ГСА Нийгмийн Даатгалын Хэлтэс	-	5 843,02	5 843,02		100,0
91	Нефрит ХХК	-	5 825,60	5 825,60		100,0
92	Эрд хул металл ХХК	-	5 700,00	5 700,00		100,0
93	Сансоресурс ХХК	67 636,80	-		- 67 636,80	- 100,0
94	Кью Си Эм ХХК	101 969,91	-		- 101 969,91	- 100,0
95	Хоричар мэргэн ХХК	34 601,00	-		- 34 601,00	- 100,0
96	Цэцэнгэрс ХХК	-	66 389,43	66 389,43		100,0
97	Мон Цахим ХХК	27 097,29	-		- 27 097,29	- 100,0
98	Багануур Илч ХХК	11 398,36	-		- 11 398,36	- 100,0
99	Универсал автокомплекс	25,48	-		- 25,48	- 100,0
100	Наран-экспорт ХХК	52 002,51	-		- 52 002,51	- 100,0
101	Минериал ресурс ХХК	17 285,00	-		- 17 285,00	- 100,0
102	Монос фарм трейд ХХК	7 728,21	-		- 7 728,21	- 100,0
103	Монгол их коал ХХК	16 698,89	-		- 16 698,89	- 100,0
104	Гепро ХХК	43 625,00	-		- 43 625,00	- 100,0
105	Эрхэс цолмон ХХК	8 650,00	-		- 8 650,00	- 100,0
106	Эсэсэн ХХК	11 749,80	-		- 11 749,80	- 100,0
107	БОАПО ХХК	23 760,00	-		- 23 760,00	- 100,0
108	Монкаротаж ХХК	12 722,40	-		- 12 722,40	- 100,0
109	Инноболор Нэмэр ХХК	15 400,00	-		- 15 400,00	- 100,0
110	Юго западный дом ХХК	50 391,80	-		- 50 391,80	- 100,0
111	Жи Ай Эм Жи ХХК	82 594,00	-		- 82 594,00	- 100,0
112	Шадар дайван ХХК	46 200,00	-		- 46 200,00	- 100,0
113	Си Эй Ти Ди ХХК	9 983,60	-		- 9 983,60	- 100,0
114	Өнөр Амьдрал ХХК	7 500,00	-		- 7 500,00	- 100,0
115	Бээжин Авиак	38 158,27	-		- 38 158,27	- 100,0
116	Талын фокус ХХК	46 750,00	-		- 46 750,00	- 100,0
117	Их Монгол Констракшн ХХК	41 018,03	-		- 41 018,03	- 100,0
118	Насо ХХК	22 000,00	-		- 22 000,00	- 100,0
119	Сити конкрейт ХХК	23 550,00	-		- 23 550,00	- 100,0
120	Хайрхан ТОВ ХХК	8 592,57	-		- 8 592,57	- 100,0
121	Индранил хөгжил ХХК	7 200,00	-		- 7 200,00	- 100,0
122	Лха угсаа ХХК	27 256,90	-		- 27 256,90	- 100,0
123	Эко майнинг сервис ХХК	18 525,60	-		- 18 525,60	- 100,0
124	Этерналгарден ХХК	34 650,00	-		- 34 650,00	- 100,0
125	Хаш Хур Анурад ХХК	10 500,00	-		- 10 500,00	- 100,0
126	Бусад харилцагчдад өглөг	321 910,83	40 852,34		- 281 058,49	- 87,3
127	Цэвэр богино хугацаат өглөг	-	-	-		
128	Засгийн газрын дэмжлэг	3 111 820,51	3 111 820,51	-		-
129	Нийт богино хугацаат өглөг	49 386 086,26	50 848 070,23	1 461 983,96		3,0
		-	-	-		
		49 386 086,26	50 848 070,23	1 461 983,96		